



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/180

Цагаан-Уул сум

**Г**Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа  
хамтран өмчилсөн газрыг гэр бүлийн нэг  
гишүүнд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.3 дахь заалт, 21 дүээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсэг, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын Засаг даргын 2008 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 23 дугаар захирамжаар гэр бүлийн хамтын хэрэгцээнд дундаа газар өмчилсөн иргэдийн хэлцлийг харгалзан Цагаан-Уул сумын 6 дугаар багийн Жаргалантын 4 дүгээр гудамжны 1 тоотод 957 м<sup>2</sup> 765600 төгрөгний үнэ бүхий газрыг иргэн (Очирбатын Сайнбаяр)-т үнэ төлбөргүйгээр шилжүүлж өмчлүүлсүгэй.

2. Газар өмчлөгч иргэнд хуулийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (А.Энхбаатар)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2008 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 23 дугаар захирамжийн Ж.Гэрэлтуяа (Рп69030503), С.Дамдинбазар (Рп91010515), С.Нямханд (Рп96111004), С.Хонгорзул (Рп93091506), С.Санчирмаа (Рп99052206) нарт холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Иргэн Ж.Гэрэлтуяа, С.Дамдинбазар, С.Нямханд, С.Хонгорзул С.Санчирмаа нарт хууль тогтоомжид заасны дагуу газар үнэгүй өмчлөх эрхээ эдлэх боломжтой болохыг зөвлөсүгэй.

ДАРГА



С.ГОНЧИГНЯМ